



БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

№. 03.2018



ГЕРМАН-МОНГОЛЫН ХАМТАРСАН
ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ
ТӨСӨЛ

Зөвлөмжийн хураангуй

- Бэлчээр ашиглалтыг нэн даруй журамлах;
- Байгалийн хадлан бэлтгэлийг нэмэгдүүлэхгүй байх;
- Малчдын хоршоод, эрчимжсэн МАА эрхлэгчдэд тэжээлийн ургамал тариалахад зориулан газар, тоног төхөөрөмж олгож, хөнгөлөлттэй зээлд хамруулах.
- Тэжээлийн ургамлын борлуулалтын сувгууд, өртгийн сүлжээнүүдийг бий болгох;
- Тэжээлийн үйлдвэр шинээр байгуулахаас өмнө одоо ажиллаж буй үйлдвэрүүдийг бодлогоор дэмжих;
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурласан ХАА-н экстейншиний үйлчилгээг орон нутагт нэвтрүүлэх;
- Газар тариалан, МАА-н салбарын хөгжлийн бодлогод үялдсан “Малын тэжээл” дэд хөтөлбөрийг санаачилж, хэрэгжүүлэх.

Зохиогчид

Б.Эрдэнэболор, PhD
Орон нутгийн тогтвортой хөгжлийн
төлөө холбооны тэргүүн
b.erdenebolor@gmail.com

Алфред Катер, PhD
Герман-Монголын “Тогтвортой хөдөө
аж ахуй” төслийн удирдагч
a.kather@iakleipzig.de

Тэжээл үйлдвэрлэл, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх боломж, арга замууд


Тэжээлийн хангамж, хэрэглээг нэмэгдүүлэх нь МАА-н үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн ачаалал, даац хэтрэлтийг бууруулах үндсэн арга замуудын нэг мөн. Түүнчлэн тэжээлийн ургамлын тариаланг нэмэгдүүлэх, үүнд ялангуяа хөрсний үржил шимд эерэг нөлөө бүхий тэжээлийн таримлуудын тариалах асуудал нь Монгол орны газар тариалангийн тогтвортой хөгжлийн зорилтод нийцнэ. Иймд Герман-Монголын хамтарсан “Тогтвортой хөдөө аж ахуй” төслөөс тэжээлийн зах зээлийн өнөөгийн байдал, дотоодын тэжээл үйлдвэрлэл, тэжээлийн хэрэглээнд тулгарч буй бэрхшээлүүд ба тэжээлийн зах зээлийн цаашдын хөгжлийн боломжуудын талаар мэдээлэл, зөвлөмжийг тус салбарын бодлого боловсруулагчид, бусад оролцогч талуудад нэгтгэн хүргэх зорилгоор тэжээлийн зах зээлийн судалгааг гүйцэтгэж, судалгааны үр дүнд тулгуурласан энэхүү бодлогын зөвлөмжийг толилуулж байна.

Тэжээл нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зах зээлийн багтаамж бий.


Монгол улсын тэжээлийн зах зээлийн өнөөгийн үнэлгээ 321 тэрбум төгрөг. Тэжээл нийлүүлэлт 2016 оны байдлаар 1.4 сая тонн байсны 75%-ийг бүдүүн ба шүүст тэжээл, 21%-ийг эрдэс тэжээл, 5%-ийг хүчит тэжээл эзэлж байна.



Тэжээл худалдан авагчдад малчид, аймаг сумдын нөөцийн фондууд болон эрчимжсэн МАА эрхлэгчид багтана. Малчдын тэжээлийн нийт хэрэглээ 2016 онд 232.8 тэрбум төгрөг, эрчимжсэн МАА эрхлэгчдийн хэрэглээ 88.1 тэрбум төгрөг байв. Бүдүүн ба шүүст тэжээлийн зах зээлд өвсний нийлүүлэлт давамгайлж буй бөгөөд гол хэрэглэгчид нь малчид (1-р зураг). Харин хүчит тэжээлийн зах зээлийн малчдын эзлэх жин харьцангуй бага. 2016 онд нийт хэрэглээний 78.9% буюу 65.9 тэрбум төгрөгийн хүчит тэжээл эрчимжсэн МАА эрхлэгчид ногдсон бөгөөд үүний дотор шувууны аж ахуйнууд хэрэглээний 35.5%-ийг дангаараа эзэлж байна (2-р зураг).



Зураг 1: Бүдүүн ба шүүст тэжээлийн хэрэглээний бүтэц, мөнгөн дүнгээс шилжүүлсэн хувиар (2016)



Зураг 2: Хүчит тэжээлийн хэрэглээний бүтэц, мөнгөн дүнгээс шилжүүлсэн хувиар (2016)

Эрчимжсэн МАА эрхлэгчдийн тэжээлийн хэрэглээ нь бүдүүн ба шүүст тэжээлийн нийт хэрэгцээнийх нь 86%, хүчит тэжээлийн хэрэгцээний 51%-ийг тус тус хангаж буй бөгөөд хэрэгцээг нь бүрэн хангахад 50 орчим тэрбум төгрөгийн тэжээл нэмж шаардагдана. Бэлчээрийн мал аж ахуйн хувьд малын тооны өсөлтөөс хамааран тэжээлийн хэрэглээ цаашид жилд 10-20 хувиар өсөх хандлагатай байна. Гэвч үүнд цаг агаарын байдал зэрэг бусад хүчит зүйл давхар нөлөөлнө. Тэжээлийн ургамлын тариаланг зөвхөн импортыг орлуулах түвшинд нэмэгдүүлэхэд 14.5 тэрбум төгрөгийн зах зээлийн багтаамж байна. Тэжээлийн ургамлын борлуулалт, хэрэглээг нэмэгдүүлэх талаар төр, хувийн хэвшлийн зүгээс санаачлагатай ажиллах замаар дотоодын тариаланг үүнээс ч илүү нэмэгдүүлэх боломжтой. Тэжээлийн хангамж, хэрэглээг нэмэгдүүлэх бодлогын түвшинд Монгол улсын тэжээлийн зах зээлийн нийт багтаамжийг 370-500 тэрбум төгрөгөөр баримжаалан тооцож болно.

Тэжээлийн зах зээлд тулгарч буй гол бэрхшээлүүд, тэжээлийн талаар төрөөс баримталж буй бодлогын сул талууд ба дутагдаж буй шийдлүүд, эдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн бодлогын зөвлөмжийг дараахь хэсэгт товч танилцуулна.

**Бэлчээрийн даац хэтэрч, байгалийн хадлан бэлтгэх хүчин чадал хомсдож байна.**

Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 71% нь бэлчээрийн зориулалтаар үнэгүй ашиглагддаг. Малчид ба мах, сүүний үхрийн аж ахуй эрхлэгчдийн хэрэглэж буй бүдүүн тэжээл нь үндсэндээ бэлчээрийн ногоо, бэлчээрээс хадаж бэлтгэсэн өвснөөс бүрдэж байна. Малын тоо зогсолтгүй нэмэгдэж буй тул өвсний хэрэглээ цаашид жилд 100 мянга хүртэл тонноор нэмэгдэх төлөвтэй. Гэтэл нийт бэлчээрийн 65-аас доошгүй хувьд даац хэдийнэ хэтэрсэн өнөөгийн нөхцөлд хадлан бэлтгэлийг нэмэгдүүлэх боломж хомс бөгөөд цаашид харин ч бууруулах шаардлагатай. Малын тэжээлийн талаарх төрийн бодлого байгалийн хомс нөөцийг ашиглахад бус, харин шинээр биомасс үйлдвэрлэх замаар тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэхэд нэн тэргүүнд чиглэх нь зохистой. Бэлчээр ашиглалтыг даруй журамлах, цаашид өвсний хэрэглээг бууруулж, ногоон тэжээл, тэжээлийн олон наст ургамал, буурцагт ургамлууд, даршны хэрэглээг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Бодлогын зөвлөмж:

- Бэлчээр ашиглалтыг хянах, бэлчээрийн тогтвортой ашиглалт, хамгаалалтыг хангах эрх зүйн зохицуулалт бий болгох;
- Малчид, эрчимжсэн МАА эрхлэгчдэд байгалийн хадлан бэлтгэх зориулалтаар тоног төхөөрөмж хөнгөлөлттэй нөхцлөөр олгож буй бодлогын дэмжлэгийг зогсоох.

Малчид, эрчимжсэн МАА эрхлэгчид тэжээлийн ургамлын тариалан эрхлэхэд тариалангийн газар, тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгө дутагдаж байна.

2016 оны байдлаар ногоон тэжээлийн таримлуудыг 20 аймагт, царгас, хошоонгор зэрэг тэжээлийн олон наст ургамлуудыг 14 аймагт, эрдэнэ шиш, наранцэцэг зэрэг даршны ургамлуудыг 8 аймагт тариалжээ. Тэжээлийн ургамал тариалагсдын ихэнхи нь болох малчид, малчдын хоршоод болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид одоогоор харьцангуй бага талбайд, зарим нь бүр 0.1 га хүртэл багахан хэмжээний газарт дөнгөж түршилтын түвшинд тэжээлийн тариалан эрхэлж байна. Уг санаачилгуудыг цаашид бодлогоор дэмжиж өргөжүүлэх нь зүйтэй. Тэжээлийн ургамал тариалалтаа нэмэгдүүлэхэд малчид, фермерүүдэд тариалангийн газар, тоног төхөөрөмж, үр болон эргэлтийн хөрөнгө шаардагдаж байна.

Бодлогын зөвлөмж:

- Орон нутгийн захиргаа, малчдын хоршоод, эрчимжсэн МАА эрхлэгчдэд тэжээлийн ургамлын тариалангийн зориулалтаар тариалангийн газар ашиглуулах, тэжээлийн таримлын үр, тариалангийн тоног төхөөрөмж хөнгөлөлттэй нөхцлөөр олгох;
- Тэжээлийн ургамлын тариалан эрхлэхээр төлөвлөсөн малчид, фермерүүдийг бодлогын зээл, тусламжид түлхүү хамруулах;



- Тэжээлийн ургамлын тариалан эрхлэхэд тохиромжтой бүс нутгуудад аймаг буюу сумын түвшинд орон нутгийн захиргаа ба малчдын хоршоодын хамтарсан түншлэлийн хэлбэрээр тэжээлийн аж ахуйнууд байгуулах.

Санал болгосон төр, хувийн хэвшлийн түншлэлийн загварт орон нутгийн захиргаа нь тариалангийн газар, мэргэжилтнээр хангаж, тариалсан тэжээлийн ургамлын борлуулалтыг хариуцах, харин малчдын зүгээс тоног төхөөрөмж, ажиллах хүч болон эргэлтийн хөрөнгийг гаргах зарчмаар хамтран ажиллах нь зүйтэй. Ингэснээр малчид тариалангийн ажлыг дангаараа бус орон нутаг, мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр, эрсдэл багатайгаар зохион байгуулах боломж бүрдэх юм. Уг загварыг төрөөс санаачлан хэрэгжүүлэх тохиолдолд хөнгөлөлттэй зээлийн тусламжийг хавсарган үзүүлэх нь зүйтэй.

Тэжээлийн ургамлын тариалалтад эдийн засаг, зах зээлийн хөшүүрэг дутагдаж байна.

Малчид, эрчимжсэн МАА эрхлэгчдийн тэжээлийн ургамал тариалах санаачлагыг төрөөс бодлогоор дэмжих нь зүйтэй боловч хөрс, цаг уурын нөхцлөөс шалтгаалан зарим нутагт уг бодлого хэрэгжих боломжгүй. Иймд тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх бодлогын нэг үндсэн чиглэл нь газар тариалангийн бүс нутгууд дахь тариалангийн механикжсан аж ахуйнууд тэжээлийн ургамал тариалах санаачилгыг дэмжих явдал юм. Тариалангийн механикжсан аж ахуйнууд тэжээлийн ургамлын тариалан эрхлэхэд 1-т тэжээлийн ургамлын борлуулалт баталгаатай байх, 2-т борлуулах үнэ нь тэжээлийн ургамлын өөрийн өртгөөс давсан байх гэсэн 2 үндсэн нөхцөл бүрдсэн байх ёстой. Эдгээр нөхцлүүдийг бүрдүүлэхийн тулд тэжээлийн ургамлын борлуулалтын сүвгүүд, өртгийн сүлжээнүүдийг бий болгоход төрийн бодлогыг чиглүүлэх нь зүйтэй. Түүнчлэн голлох таримал болох буудайн сэлгээнд тэжээлийн ургамал тариалах нь хөрсний үржил шимд эерэгээр нөлөөлөх тул уг сэлгээг мөрдөж буй аж ахуйнуудад бодлогын дэмжлэг үзүүлэх нь зохистой.

Бодлогын зөвлөмж:

- Аймаг сумдын аюулгүйн нөөцөд байгалийн хадлангийн оронд ногоон тэжээл, тэжээлийн олон наст болон уурагт тэжээлийн таримлууд нийлүүлэх;
- Дайвар бүтээгдэхүүнийг нь малын тэжээлд ашиглах боломжтой рапс, шар буурцаг, гич зэрэг таримал ургамлуудыг боловсруулах үйлдвэрүүдэд бодлогын дэмжлэг үзүүлэх (хөнгөлөлттэй зээл, татварын хөнгөлөлт г.м.);
- Тэжээлийн ургамлын тариалан эрхлэхээр, эсвэл дотоодын тариалан эрхлэгчдээс тэжээлийн ургамал худалдан авахаар төлөвлөсөн эрчимжсэн МАА эрхлэгчдийг бодлогын зээл, тусламжид түлхүү хамруулах;
- Тариаланчдад буудайн урамшуулал ба шатахуун, бордоо, ургамал хамгааллын бодисыг хөнгөлөлттэй нөхцлөөр олгоход шатлал бий болгож, сэлгээнд тэжээлийн ургамал тариалж буй тариаланчдад харьцангуй давуу тал эдлүүлэх.



Тэжээл үйлдвэрлэлийн өнөөгийн хүчин чадал бүрэн ашиглагдаагүй байхад нэмж тэжээлийн үйлдвэр барих шаардлагагүй.

ХХААХҮЯ-нд бүртгэгдсэн тэжээл үйлдвэрлэлийн 116 нэгжийн нийлбэр хүчин чадал нь жилд 374 мянган тонн. Эдгээрээс 2017 оны байдлаар 68 нь ажиллаж байна. Үүнд 11 тэжээлийн үйлдвэр, 30 гурилын үйлдвэр, хорголжилсон тэжээл бэлтгэдэг 2 тээрэм, мөн хорголжилсон тэжээл бэлтгэгч, үр тарианы бутлуур, тэжээл холигч зэрэг бага оврын тоног төхөөрөмж бүхий 23 хоршоо, фермерийн аж ахуйнууд багтана. Аж үйлдвэрийн түвшинд тэжээл үйлдвэрлэж буй 41 ААН-ийн нийлбэр хүчин чадал нь жилд 263 мянган тонн бөгөөд одоогоор уг хүчин чадлын 38%-ийг нь ашиглаж байна. Бага оврын тэжээл үйлдвэрлэлийн хувьд бүртгэгдсэн 53 нэгжээс 23 нь л ажиллаж байна. Ийнхүү тэжээл үйлдвэрлэлийн хүчин чадал бүрэн ашиглагдаагүй байхад 2017-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт шинээр 4 тэжээлийн үйлдвэр барих, мөн малчид, фермерүүдэд тэжээл бэлтгэлийн бага оврын тоног төхөөрөмж нэмж тараахаар төлөвлөжээ. Шинээр байгуулах тэжээлийн үйлдвэрүүд бүтээгдэхүүнээ зах зээлд гаргаж чадах эсэх нь тодорхойгүй, мөн өмнө нь малчид, фермерүүдэд олгосон тоног төхөөрөмжүүдийн ихэнхи нь ашиглагдаагүй байхад нэмж олгох нь оновчтой бус шийдэл юм. Өнөөгийн нөхцөлд үйлдвэрлэлийн нэмэлт хүчин чадал бий болгох нь нийт тэжээл үйлдвэрлэлд нэмэр болох бус харин ч сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Харин одоо ажиллаж буй тэжээлийн үйлдвэрүүдээ дэмжиж, хүчин чадлыг нь бүрэн дүүрэн ашиглахад илүүтэй анхаарах нь зүйтэй.

Бодлогын зөвлөмж:

- Нэмж тэжээлийн үйлдвэр байгуулах төлөвлөгөөг тэжээл үйлдвэрлэлийн өнөөгийн хүчин чадлын дор хаяж 50% нь ашиглагдах хүртэл хойшлуулах. Үүний оронд одоо ажиллаж буй тэжээл үйлдвэрлэгчдэд бодлогын дэмжлэг үзүүлэх (хөнгөлөлттэй зээл, татварын хөнгөлөлт г.м.);
- Малчид, эрчимжсэн МАА эрхлэгчдэд тэжээл үйлдвэрлэлийн бага оврын тоног төхөөрөмж хөнгөлөлттэй нөхцлөөр олгох ажлыг зогсоох.

Малын тэжээл, тэжээллэг хангалтгүй байгаа нь малчид, фермерүүдийн мэдлэгийн хомсдолтой салшгүй холбоотой.

Мал аж ахуйн эрхлэгчид малаа зөв тэжээх талаар мэдлэг, мэдээлэл багатай байгаа нь тэжээлийн хэрэглээ, орц найрлага хангалтгүй бөгөөд зохисгүй байгаагийн нэг томоохон шалтгаан мөн. Малын тэжээл, тэжээллэгийг сайжруулахын тулд төрөөс ХАА-н зөвлөх, нэвтрүүлэх (экстейншиний) үйлчилгээг орон даяар бий болгох, бэхжүүлэх шаардлагатай.

Бодлогын зөвлөмж:

- Сумдын МАА-н мэргэжилтнүүдэд малчдад тэжээл, тэжээллэгийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх мэдлэг, үр чадвар олгох;



- Сумдын МЭҮТ-үүдийг тэжээл бэлтгэл, бэлчээрийн малыг тэжээх тухай хялбарчилсан товхимол, гарын авлага, сургалтын видео зэрэг сургалт сурталчилгааны материалаар хангах;
- Аймгийн ХХААГ-ууд дахь Нэвтрүүлэх төвүүдийн (ХААНТ-үүдийн) үйл ажиллагааг сэргээх, эрчимжүүлэх, тухайлбал ХААНТ бүрийг тэжээлийн ургамлын тариалангийн үзүүлэнгийн талбай, бага оврын тариалангийн тоног төхөөрөмж, сургалтын өрөө болон үйл ажиллагааны төсвөөр хангах;
- ХХААХҮЯ-д ХАА-н экстейншиний нэгдсэн зохицуулалт хариуцсан орон тоо бий болгох;
- Эрчимжсэн МАА эрхлэгчдэд тэжээл бэлтгэл, малын тэжээллэгийн сэдвээр цуврал сургалтуудыг жил бүр зохион байгуулах.
- Орон тооны МАА-н мэргэжилтэн ажиллуулдаг, эсвэл мэргэжилтнүүдтэй хамтран ажилладаг эрчимжсэн МАА эрхлэгчдийг бодлогын дэмжлэгт түлхүү хамруулах.

Тэжээлийн талаар баримталж буй төрийн бодлогын мал аж ахуй, газар тариалангийн салбар дахь хэрэгжилтэд нэгдсэн цар хүрээ дутагдаж байна.

Тэжээл үйлдвэрлэлийн асуудал нь МАА, газар тариалангийн салбарын аль алинд хамааралтай нь нэг талаар давуу тал боловч нөгөө талаар тухайн салбарын бусад тэргүүлэх чиглэлүүдэд шахагдаж үл хайхрагдах эрсдэлтэй. Түүнчлэн тэжээлийн үйлдвэрлэл, хэрэглээний талаарх статистик мэдээ хангалтгүй байна.

Бодлогын зөвлөмж:

- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын хүрээнд “Малын тэжээл” дэд хөтөлбөр боловсруулж, МАА, газар тариалангийн салбарт хэрэгжиж буй төрийн бодлогод уялдуулан хэрэгжүүлэх;
- Тэжээл, тэжээллэгийн судалгаа, инновацийн төслүү, старт-ап компаниудад бодлогын дэмжлэг үзүүлэх;
- Тэжээл үйлдвэрлэлийн статистик мэдээний хүртээмж, чанарыг сайжруулах;

Дүгнэлт

- Тэжээлийн зах зээлийн өнөөгийн үнэлгээ 321 тэрбум төгрөг бөгөөд бодлого боловсруулахад баримжаалах боломжит багтаамж нь 370-500 тэрбум төгрөг.
- Малын тэжээлд байгалийн бэлчээрээс хадаж бэлтгэсэн өвсний хэрэглээ давамгайлж буй нь бэлчээрийн ачааллыг улам нэмэгдүүлж байна. Цаашид малын тоо өсөх, үүнийг дагаж өвсний хэрэгцээ нэмэгдэх хандлагатай тул бэлчээр ашиглалтыг нэн даруй журамлах, тэжээлийн ургамлын тариаланг нэмэгдүүлэх шаардлагатай.



- Малчид, эрчимжсэн МАА эрхлэгчдийн тэжээлийн ургамал тариалж буй санаачлагуудыг бодлогоор дэмжин өргөжүүлэх, үүний тулд тариалангийн газар, тоног төхөөрөмжөөр хангах шаардлагатай. Мөн тэжээлийн ургамал тариалж буй газар тариалангийн аж ахуйнуудад урамшуулал олгох, тэжээлийн ургамлын борлуулалтын сувгууд, өртгийн сүлжээнүүдийг бий болгох зэрэг арга замуудаар тэжээлийн ургамлын тариаланг нэмэгдүүлэх нь зүйтэй.
- Тэжээлийн үйлдвэр шинээр барих төлөвлөгөөг хойшлуулах, харин одоо ажиллаж буй тэжээлийн үйлдвэрүүдээ дэмжиж, хүчин чадлыг нь бүрэн дүүрэн ашиглахад түлхүү анхаарах нь зохистой.
- Малын тэжээл, тэжээллэг хангалтгүй байгаа нь малчид, фермерүүдийн мэдлэг, мэдээллийн хомсдолтой салшгүй уялдаатай болохыг бодлогын түвшинд анхаарч, зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурласан ХАА-н экстейншиний үйлчилгээний бүтцийг орон даяар бий болгох нь малын тэжээлийн үйлдвэрлэл, хэрэглээг тогтвортой сайжруулахад шийдвэрлэх үүрэгтэй. Малчид, фермерүүдийг мэдлэг, мэдээллээр хангах тогтолцоо бүрдээгүй нөхцөлд тэжээлийн хангамж, хэрэглээг нэмэгдүүлэх бодлогын бусад арга хэмжээний үр дүн хязгаарлагдмал байх болно.
- Малын тэжээлийн асуудал нь газар тариалан, МАА-н салбарын хавсарсан шинж чанартай учраас бодлогын шийдвэр, шийдлүүдийг хэрэгжүүлэх ерөнхий цар хүрээ дутагдаж байна. Иймд Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын хүрээнд “Малын тэжээл” дэд хөтөлбөрийг санаачилж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

**Ашигласан зарим хэвлэл:**

- DLG e.V. (2009). Empfehlungen zur Fütterung von Mutterkühen und deren Nachzucht. Retrieved on 15 August 2017 from <http://www.dlg.org/fachinfos-rinder.html>.
- Durst, L. and Wittmann, M. (2001). Tierernährung. Triesdorf: Fachhochschule Weihenstephan, Abteilung Triesdorf.
- Гүрбазар, Д., Ринчиндорж, Д. and Мөнгөнбагана, Т. (2017). Тэжээл үйлдвэрлэл. Хөдөө аж ахуйн их сургууль: “Тэжээл үйлдвэрлэл, зах зээл” семинарын илтгэлүүдийн эмхэтгэл.
- Kalashnikov, A.P. , W. Scheglov, V.V. and Pervov, N.G. (eds.) (2007). Тэжээлийн норм, жор. 3-р хэвлэл. Москва: ОХУ-ын Хөдөө аж ахуйн яам, Оросын ХАА-н шинжлэх ухааны академи ба Бүх Оросын Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн. *Монгол орчуулга (орчуулагч Х.Гэндарам)*.
- Kirchgessner, M. (2004). Tierernährung. Leitfaden für Studium, Beratung und Praxis. 11. neu überarbeitete Auflage. Frankfurt am Main: DLG Verlag.
- Нямбат, Л. and Гэрэлхүү, Т. (2017). Монгол орны мал сүргийн тоо, бүтэц: Бэлчээр, тэжээл. Хөдөө аж ахуйн их сургууль: “Тэжээл үйлдвэрлэл, зах зээл” семинарын илтгэлүүдийн эмхэтгэл.
- Тогтохбаяр, Н., Жигжидсүрэн, С. and Содномцэрэн, Ч. (2017). Тэжээл үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, хөгжлийн бодлого. Хөдөө аж ахуйн их сургууль: “Тэжээл үйлдвэрлэл, зах зээл” семинарын илтгэлүүдийн эмхэтгэл.



Тайлбар: Энэхүү бодлогын зөвлөмжид багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогчид хариуцна. Уг зөвлөмж нь Монгол-Германы хамтарсан “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийг санхүүжүүлэгч ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.



“Тогтвортой хөдөө аж ахуй” төслийг зөвлөх үйлчилгээний IAK Agrar Consulting, AFC Consulting International, DLG International компаниуд, ХАА-н сургалтын DEULA Nienburg төвийн хамтарсан консорциум хэрэгжүүлдэг. Уг консорциумыг тэргүүлэгч IAK Agrar Consulting ХХК нь ХАА-н хараат бус, мэргэшсэн зөвлөх үйлчилгээг төрийн байгууллагууд, 180 гаруй ААН-үүдэд үзүүлж, төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг. IAK Agrar Consulting ХХК-ийн Герман болон гадаад улс орнууд дахь үндсэн үйл ажиллагаа болох ХАА-н зөвлөх үйлчилгээ нь төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагууд, хувийн хэвшлийн ААН-үүд, нийгэмлэг, холбоод болон олон улсын байгууллагуудад хамруулдан. Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд хөдөөгийн ба хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил, ХАА-н боловсролыг дэмжих чиглэлээр ХБНГУ-ын ХХААЯ, GIZ, Европын Холбоо, Дэлхийн банк зэрэг донор байгууллагуудын санхүүжилттэй төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Вэбсайт: www.iakleipzig.de